

МОНГОЛ УЛСЫН СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ 2017 ОНД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Монгол Улсын Соёл урлагийн их сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2016 онд Улаанбаатар хотоос оюутан элсүүлэхэд БШУ-ны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, 2014 оны А/78 дугаар тушаалаар батлагдсан Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл (хөтөлбөр), индекс, БСШУ-ны сайдын 2016 оны А/86 дугаар тушаал болон энэхүү журмыг баримтална.
- 1.2. СУИС-д элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.3. СУИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “бүртгүүлэгч”, зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг “элсэлтийн комисс” гэнэ.
- 1.4. СУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт Улаанбаатар хот болон аймгуудаас элсүүлэх оюутны хяналтын тоог Удирдах зөвлөл тогтооно.
- 1.5. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.
- 1.6. Энэхүү журам болон нэмэлт мэдээллийг www.msua.edu.mn, www.suis.edu.mn/elselt цахим хуудсанд байрлуулна.
- 1.7. СУИС-д элсэхийг хүссэн гадаадын харьяат иргэдийн асуудлыг “Монгол улсын Соёл урлагийн их сургуульд гадаадын иргэдийг суралцуулах журам”-аар зохицуулна.
- 1.8. СУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт аймаг, орон нутгаас оюутан элсүүлэх ажлыг “Аймаг орон нутгаас Монголын их, дээд сургуулиудын консорциум (МИДСК)-ын гишүүн их, дээд сургууль, коллежид 2017 онд оюутан элсүүлэх журам”-ыг баримтлан МИДСК-аас томилогдсон элсэлтийн комисс зохион байгуулна.

2. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. Бүртгүүлэгч нь оршин суух бүртгэл харгалзахгүйгээр Улаанбаатар хотод бүртгүүлж, шалгалт өгч болно.
- 2.2. Бүртгүүлэгч нь Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан монгол хэл, бичгийн шалгалтыг өгсөн байна.
- 2.3. Бүртгүүлэгч нь бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой, элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ыг 2015, 2016, 2017 онд өгч, элсэхийг хүссэн хөтөлбөрийн босго оноог хангасан байна. Оюутан элсүүлэх хөтөлбөр, өгсөн байвал зохих ЭЕШ, бүртгэлийн босго оноо, ур чадварын шалгалтын агуулгыг хавсралтад заав.
- 2.4. Бүртгүүлэгч ЭЕШ-ыг хэд хэдэн удаа өгсөн тохиолдолд илүү оноотой аль нэг батламжаар бүртгүүлнэ.
- 2.5. Бүртгүүлэгч СУИС-д бүртгүүлэхээс өмнө ЭЕШ-тай холбоотой асуудал байвал урьдчилан шийдвэрлүүлсэн байх шаардлагатай.
- 2.6. Урлагийн авьяас шаардагдах хөтөлбөрөөр бүртгүүлэгч ур чадварын шалгалт өгнө.
- 2.7. Гадаад оронд бүрэн дунд боловсрол эзэмшсэн Монгол улсын иргэн СУИС-д элсэх хүсэлт гаргахдаа элсэхийг хүсч буй хөтөлбөрөөр өгвөл зохих ЭЕШ-тай дүйцүүлж болох шалгалтыг гадаад оронд өгсөн тухай батламжийг Элсэлтийн комисст ирүүлсэн байна.
- 2.8. Хоёр дахь дээд боловсролыг өдрийн хөтөлбөрөөр эзэмшихээр бүртгүүлэгч нь Элсэлтийн комисст өөрийн биеэр ирж бүртгэлээ баталгаажуулна (ирэхдээ боловсролын зэргийн

дипломыг эх хувиар нь авч ирнэ). Эдгээр иргэдээс ЭЕШ өгсөн байхыг шаардахгүй, зөвхөн ур чадварын шалгалт авна.

3. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

- 3.1. ЭЕШ-ын бүртгэлийн босгыг хангасан бүртгүүлэгч www.suis.edu.mn/elselt цахим бүртгэлийн системээр бүртгүүлнэ (бүртгүүлэх зааварчилгаатай цахим хуудаснаас урьдчилан танилцана уу).
- Бүртгэл эхлэх хугацаа: 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 09:00 цагт нээж,
Бүртгэл дуусах хугацаа:
- Ур чадварын шалгалт өгч элсэх хөтөлбөр: 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 18.00 цаг
 - ЭЕШ-ын оноогоор элсэх хөтөлбөр: 2017 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 12.00 цаг.
- 3.2. ЭЕШ-ын оноогоор элсүүлэх хөтөлбөрийн бүртгэлийн хураамж 8,000 төгрөг, ур чадварын шалгалт авч элсүүлэх хөтөлбөрийн бүртгэлийн хураамж 15,000 төгрөг байна.
- 3.3. Бүртгүүлэгч нь нэг түүнээс дээш хөтөлбөрт бүртгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд хөтөлбөр тус бүрээр бүртгэлийн хураамж төлнө.
- 3.4. Бүртгүүлэгч бүртгүүлэхийг хүссэн хөтөлбөрийг бүртгэлийн цахим системд сонгосон үед төлбөл зохих нийт хураамжийн хэмжээ гарах бөгөөд уг мэдээлэлтэй танилцаад хураамжийг Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк, Голомт банкны төлбөрийн картыг ашиглан цахим хэлбэрээр шилжүүлнэ.
- 3.5. СУИС-ийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж, “Бадмаараг” ахлах сургууль, Улаанбаатар хотын Хөгжим бүжгийн коллежид гүнзгийрэн суралцсан чиглэлийн дагуу элсэхийг хүсэгчийг ЭЕШ өгч, бүртгэлийн босго онооны болзлыг хангасан тохиолдолд ур чадварын шалгалт авахгүйгээр хяналтын тоонд багтаан тухайн хөтөлбөрт элсүүлэх бөгөөд бүртгэлийн хугацаанд Элсэлтийн комисст өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.
- 3.6. Ур чадварын шалгалтаас чөлөөлөгдсөн элсэгч нь бүртгэлийн хураамж 8,000 төгрөг төлнө.
- 3.7. Цахим бүртгэл хийж байх үед СУИС-ийн бүтцийн сургуулиуд хэрэгжүүлж буй бакалаврын хөтөлбөрүүдээ танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг хүлээнэ.

4. ЭЛСЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ БА МЭДЭГДЭХ

- 4.1. Ур чадвар шаардах хөтөлбөрийн элсэлтийн шалгалтыг 2017 оны 7 дугаар сарын 5, 6, 7-ны өдрүүдэд тусгай хуваарийн дагуу зохион байгуулна. Хуваарийг СУИС-ийн www.suis.edu.mn/elselt болон www.msua.edu.mn цахим хуудсаар болон хичээлийн төв байрны мэдээллийн цахим самбараар мэдээнэ.
- 4.2. Ур чадвар шаардах хөтөлбөрт элсүүлэх оноог ЭЕШ-ын онооны 50 хувь (400 хүртэл), ур чадварын шалгалтын онооны 100 хувийн (800 хүртэл) нийлбэр (1200 хүртэл)-ээр тооцно.
- 4.3. Нийт оноо тэнцсэн тохиолдолд бүрэн дунд боловсролын гэрчилгээний дундаж оноог харгалзана.
- 4.4. СУИС-ийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж, Улаанбаатар хотын Хөгжим бүжгийн коллежийн төгсөгч болон “СУИС-д суралцах урилга”-тай иргэдийг ЭЕШ өгч, бүртгэлийн босго онооны болзлыг хангасан тохиолдолд ур чадварын шалгалт авахгүйгээр хяналтын тоонд багтаан тухайн хөтөлбөрт элсүүлнэ.
- 4.5. Элсэлтийн эцсийн дүнг 2017 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 18.00 цагт СУИС-ийн www.msua.edu.mn цахим хуудас болон Төв байрны мэдээллийн самбар дээр байрлуулна.

5. ЭЛСЭХ ЭРХ ОЛГОХ

- 5.1. Хяналтын тоонд багтсан элсэгчдэд “Суралцах эрхийн бичиг” олгоно.
- 5.2. “Суралцах эрхийн бичиг”-ийг
- 2017 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 9.00-18.00 цагт
 - 2017 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 9.00-13.00 цагт СУИС-ийн төв байранд олгоно.
- 5.3. Зарласан хугацаанд “Суралцах эрхийн бичиг”-ээ аваагүй тохиолдолд онооны дарааллаар дараагийн хүнд хуваарийг шилжүүлнэ. Энэ тухай бүртгүүлсэн утасны дугаараар мэдэгдэж,

“Суралцах эрхийн бичиг”-ийг 2017 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 13.00-18.00 цагт СУИС-ийн төв байранд олгоно.

- 5.4. Элсэгч “Суралцах эрхийн бичиг”, “Эрүүл мэндийн үзлэгийн хуудас”-ыг авахаар ирэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:
1. Бүрэн дунд боловсролын гэрчилгээ, хоёр дахь дээд боловсрол эзэмших бол дипломын эх хувь, нотариатаар баталгаажуулсан хуулбар;
 2. ЭЕШ-ын батламж;
 3. Сурагчийн хувийн хэрэг;
 4. Цахим үнэмлэх, хуулбарын хамт;
 5. Эцэг/эхийн цахим үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
 6. Сүүлийн 6 сарын хугацаанд авахуулсан 3x4 хэмжээтэй 6 хувь зураг;
- Эдгээр материалыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.
- 5.5. Элсэлтийн материалыг хуурамчаар үйлдсэн иргэнийг СУИС-д элсүүлэхгүй бөгөөд элсэн тохиолдолд хасна.

6. ЭЛСЭГЧДИЙН БҮРТГЭЛ

- 6.1. “Суралцах эрхийн бичиг” авсан элсэгч нь 2017 оны 8 дугаар сарын 15-наас 31-ний өдрүүдэд бүтцийн сургуулийн сургалтын албанд бүртгүүлж, хичээл сонголтоо хийнэ.
- 6.2. Бүртгүүлэхдээ дараах материалыг авч ирнэ. Үүнд:
- 6.2.1. Эрүүл мэндийн үзлэгт орж баталгаажуулсан хуудас (маягтыг сургуулиас авах);
 - 6.2.2. Сургалтын төлбөрийн урьдчилгаа төлбөрийг бүтцийн сургуулийнхаа харилцах дансанд тушаасан баримт;
 - 6.2.3. Суралцах эрхийн бичиг;
- 6.3. “Суралцах эрхийн бичиг” авсан боловч заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчийг элсэхээс татгалзсан гэж үзэж элсэх эрхийг хүчингүйд тооцно.

7. ЭЛСЭЛТИЙН КОМИССЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 7.1. Элсэлтийн комисс нь бүртгүүлэгчдийн мэдлэг, авъяас, чадварыг үнэн зөв, шударга, бодитой үнэлэн сонгон шалгаруулах үүрэгтэй.
- 7.2. Оюутан элсүүлэхтэй холбоотой аливаа маргааныг “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, БШУ-ны Сайдын баталсан “Оюутан элсүүлэх журам”, бусад холбогдох хууль, дүрэм журам болон энэхүү журмыг баримтлан элсэлтийн шалгалтын комисс ажлын 7 хоногт багтаан эцэслэн шийдвэрлэнэ.

8. БУСАД

- 8.1. Аймаг, орон нутагт элсэлт зохион байгуулах салбар комисс нь батлагдсан удирдамжийн дагуу ажиллана.
- 8.2. Салбар комисс нь сургуульд оюутан элсүүлэх болзлыг хангаж, суралцах хөтөлбөрөө сонгосон элсэгчдэд суралцах эрхийн бичиг олгоно.
- 8.3. Элсэгчдээс Боловсролын үнэлгээний төвийн баталгаажилт бүхий батламж бичиг, бүрэн дунд боловсролын гэрчилгээг хураан авч, битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.
- 8.4. Элсэгчдийн материалыг 2017.08.15-наас 20-ны дотор бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албанд хүлээлгэн өгч, элсэлт авсан тухай тайлан бичсэнээр үүрэгт ажлыг дуусгавар болгоно.

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 26

Харилцах утас: 11-326129, 89164844, 95184844, 98184855

(Сургалтын бодлого, зохицуулалтын газар)

Цахим хаяг: www.msuac.edu.mn, www.suis.edu.mn/elselt

<http://www.facebook.com/msuac>, <https://twitter.com/MSUAC>

info@msuac.edu.mn,

**СУИС-ИЙН БАКАЛАВРЫН ӨДРИЙН СУРГАЛТАНД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ
ХӨТӨЛБӨР, ЭЭС, БҮРТГЭЛИЙН БОСГО ОНОО, УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТЫН АГУУЛГА**

А. Ур чадварын шалгалт өгч, элсэх хөтөлбөрүүд

Хөтөлбөр	Элсэлтийн ерөнхий шалгалт	Босго оноо	Ур чадварын шалгалт (800 оноо)	
			Ерөнхий чадвар	Онцлог чадвар
011404. Багш, урлагийн боловсрол <i>/хөгжмийн; бүжгийн/</i>	Аль нэг хичээлээр	400	<i>Хөгжмийн</i> а) Хөгжимдөх чадвар (төгөлдөр хуураар 2 зохиол) б) Хэмнэл в) Сонсгол, ой тогтоолт	а) Сонгосон хөгжмийн зэмсгээр 2 зохиол хөгжимдөх б) Урлагийн тухай ярилцлага в) Биеийн хөгжил г) Дуулах чадвар
			<i>Бүжгийн</i> а) Бие бялдрын хөгжил, уян хатан чанар б) Сонсгол, ой тогтоолт, хөгжмийн мэдрэмж в) Бүжиглэх авьяас чадвар г) Үсрэлт, хөдөлгөөний эвсэл	
021101. Зураг авалт	Аль нэг хичээлээр	400	а) Ярилцлага б) Оюуны чадамж IQ в) Бие дааж хийсэн ажлууд	
021102. Дуу чимээний технологи			а) Сонсгол б) Ярилцлага в) Оюуны чадамж IQ	
021201. Хувцасны дизайн	Аль нэг хичээлээр	400	а) Зохиомж б) Хар зураг в) Уран зураг г) Бие дааж хийсэн ажлууд	
021202. График дизайн <i>/компьютер график; мульти-медиа; хэвлэлийн дизайн/</i>				
021301. Уран зураг <i>/уран зураг; монгол зураг; монументаль уран зураг; тайз дэлгэцийн уран зураг/</i>				
021302. Уран баримал <i>/уран баримал; керамик урлаг; арьсан урлаг; чимэглэх урлаг; уран дархан; уран сийлбэр/</i>				
021303. Зураасан зураг				
021304. Түүх соёлын дурсгалт зүйлийн сэргээн засварлалт				
021501. Хөгжмийн урлаг <i>/зохиомж; MIDI зохиомж хөгжим судлал; удирдах-найрал дуу; найрал хөгжим/</i>	Аль нэг хичээлээр	400	а) 2-3 хоолойн диктант б) Хөгжмийн суурь мэдлэг (бодлого бодох, онолын дасгал хийх) в) Төгөлдөр хуураар хөгжимдөх ур чадвар г) Ярилцлага	а) Өөрийн зохиосон хөгжмийн зохиолыг хөгжимдөх, ноотны программын мэдлэг б) Найрал хөгжим удирдах- 2 бүтээл в) Найрал дуу удирдах-2 бүтээл, дуулах чадвар г) Урлагийн тухай эссэ бичих (250-300 үгтэй)
021502. Хөгжимдөх урлаг <i>/сонгодог хөгжим; үндэсний хөгжим; орчин цагийн хөгжим/</i>			а) Хөгжимдөх чадвар (сонгосон хөгжмийн зэмсэгээр 2 зохиол) б) Хэмнэл в) Сонсгол, ой тогтоолт	а) Сонгосон хөгжмийн зэмсгээр 2 зохиол хөгжимдөх б) Урлагийн тухай ярилцлага в) Биеийн хөгжил г) Дуулах чадвар
021503. Дуулах урлаг <i>/дуурийн; ардын; орчин цагийн/</i>			а) Дуулах чадвар (2-3 дуу) б) Хэмнэл, в) сонсгол, ой тогтоолт г) Хөгжимдөх чадвар	а) Биеийн хөгжил (хоолойн цараа, амны хөндийн эрүүл ахуй) б) Хөдөлгөөний эвсэл, бүжиг
021504. Үндэсний язгуур урлаг <i>/хөөмэй, тууль/</i>			а) Түргэн хэллэг б) Амьсгалын багтаамжийн дасгал	
021505. Жүжиглэх урлаг /кино; драмын, хөгжимт театрын/	Аль нэг хичээлээр	400	а) Өөрийн судалбар б) Хөдөлгөөний эвсэл, бүжиг в) Дуулах чадвар г) Сонсгол, ритм д) Уран уншлага	а) Ёгт үлгэр ярих б) Монолог в) Өгөгдсөн судалбар г) Ярилцлага д) Оюуны чадамж IQ

021516. Найруулах урлаг <i>/киноны; радио, телевизийн, жүжгийн/</i>	Аль нэг хичээлээр	400	а) Өөрийн судалбар б) Хөдөлгөөний эвсэл, бүжиг в) Дуулах чадвар г) Сонсгол, ритм д) Уран уншлага	а) Эссэ бичих б) Ярилцлага в) Оюуны чадамж IQ
021507. Бүжгийн урлаг <i>/бүжгийн найруулга; бүжиглэх урлаг/</i>	Аль нэг хичээлээр	400	а) Бие бялдрын хөгжил, уян хатан чанар б) Сонсгол, ой тогтоолт, хөгжмийн мэдрэмж в) Бүжиглэх авьяас чадвар г) Үсрэлт, хөдөлгөөний эвсэл	
021801. Урлаг судлал <i>/театр; кино; дүрслэх урлаг/</i>	Аль нэг хичээлээр	400	а) Эссэ бичих	а) Ярилцлага б) Оюуны чадамж IQ
023203. Утга зохиол судлал <i>/кино, жүжгийн зохиол/</i>				
032101. Сэтгүүл зүй	Аль нэг хичээлээр	400	а) Ярилцлага б) Эссэ бичих в) Оюуны чадамж IQ	

Б. Элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор элсэх хөтөлбөрүүд

Хөтөлбөр	Элсэлтийн ерөнхий шалгалт	Босго оноо
021104. Радио, дэлгэцийн техник технологи	Математик (100%) эсвэл Физик (100%)	400
031401. Соёл судлал <i>/нүүдлийн соёл судлал; өрнийн соёл судлал; соёлын өв, музей судлал/</i>	Гадаад хэл (100%) эсвэл Нийгмийн тухай мэдлэг (100%)	
032201. Номын сан судлал		
041302. Менежмент <i>/соёл, урлаг/</i>	Математик (100%) эсвэл Нийгмийн тухай мэдлэг (100%)	
041401. Маркетинг <i>/соёл, урлаг/</i>	Математик (100%) эсвэл Гадаад хэл (100%)	
101501. Аялал жуулчлал <i>/соёлын аялал жуулчлал; соёл, чөлөөт цагийн үйлчилгээ/</i>	Гадаад хэл (100%) эсвэл Нийгмийн тухай мэдлэг (100%)	